

Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1-т зааснаар тус Хороо нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллаж ирсэн бөгөөд энэ хүрээнд Хороо сүүлийн жилүүдэд эрх зүйн хүрээнд болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах практикийг сайжруулах чиглээр үр дүнтэй ажиллуудыг хийж гүйцэтгээд байна.

Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах гол хүчин зүйл байх тул Хороо дараах журмуудыг батлан гаргаад байна. Үүнээс заримыг нь дурдвал:

- Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх тухай журам;
- Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох тухай журам;
- Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам;

Мөн Хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хуулиар хүлээдэг үүрэг, хариуцлага болон үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийн талаар бүрхэг ойлголттой олон тооны жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаа нь компанийн удирдлага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх нэг шалтгаан болж байна. Дээрх байдлыг арилгаж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр Хорооны хийж гүйцэтгэсэн ажлын заримыг дурдвал:

1. Хороо хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх асуудалд төр засгийн болон зах зээлийн нийт оролцогчдын анхаарлыг хандуулах, үнэт цаас гаргагчдын хариуцлага, сахилга батыг, өөрөөр хэлбэл компанийн засаглалыг сайжруулах, мэргэжлийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, хяналт, зохицуулалтыг сайжруулах, хөрөнгө оруулагч олон нийтийн идэвхи оролцоо, мэдлэг мэдээллийг чанарын шинэ шатанд гаргах зорилгоор хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарын мэдлэг боловсрол, тэдэнд мэдээлэл хүргэх талаар анхаарал хандуулан ажиллаж байна.
2. Монгол Улсын төрийн дээд байгууллагуудын зүгээс ч сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийн тулгамдаад байгаа асуудлуудад анхаарлаа хандуулж байна. Тодруулбал, Улсын Их Хурлын “Монгол Улсын хууль тогтоомжийг 2008-2012 онуудад боловсронгуй болгох үндсэн чиглэл”, мөн 2009 онд баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, Монгол Улсын Засгийн газраас баталсан “Бизнесийн орчны шинэчлэлийн жилийн ажлын төлөвлөгөө”, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2010 оны 115 дугаар тогтоол зэрэг бодлогын баримт бичигт төрийн зүгээс хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар маш тодорхой тусгаж, зохих хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулагдан эхнээсээ хэрэгжиж эхлээд байна.

Хороонд хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тэдний зөвшөөрөлгүй биржийн арилжаагаар худалдаж, завшсан тухай өргөдлүүд ирсээр байгаа бөгөөд энэхүү зөрчлөөс үүдсэн гомдол, өргөдлийг шалгаж, шийдвэрлэх, буруутай этгээдэд хариуцлага ногдуулах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг сэргээж, хохиролгүй болгох, уг үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй эсэх талаар тогтоолгохоор харьяаллын дагуу шүүх, цагдаагийн байгууллагад шилжүүлэн ажиллаж байна. Үүнээс заримыг нь дурьдвал Орхон аймгийн иргэдэд үнэт

цаасны зах зээлд зуучлах үүрэгтэйгээр ажиллаж байсан брокер, дилерийн “Эрдэнэст” ХХК харилцагчдын үнэт цаасыг хууль бусаар худалдаж, онц их хэмжээний хохирол учруулсан гэж үзэн УМБГазарт шилжүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулж байгаа болно. Уг ажилтай холбогдуулан цагдаагийн байгууллагын ажилтнуудыг мэргэжлийн зөвлөгөө, тайлбараар ханган хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар “Эрдэнэст” ХХК-ийн буруутай хууль бус үйлдлээс хохирсон 50 гаруй иргэдийн өргөдөл тус Хороонд ирж шалгагдан, цагдаагийн байгууллагад шилжүүлсэн бөгөөд тэдний хохирлын хэмжээг тухайн үеийн хувьцааны ханшаар тооцоход 6 орчим сая төгрөг одоогийн зах зээлийн ханшаар 100 орчим сая төгрөг болж байгаа болно.

Санхүүгийн зохицуулах хороонд Завхан аймгийн Засаг даргаас хүсэлт тавьсны дагуу 5 дугаар сарын сүүлийн 10 хоногт Завхан аймагт ажиллахаар төлөвлөж, холбогдох бэлтгэл ажлыг хийж байгаа бөгөөд тус аймагт ажиллах брокер, дилерийн компанийг сонгон шалгаруулах тендерийг 2009 онд зарласан боловч ямар нэгэн компанийн зүгээс санал ирээгүй. Улмаар 2010 оны I улиралд дахин зарласан бөгөөд брокер, дилерийн “Гүүдсек” ХХК-иас санал ирүүлсэн тул Завхан аймгийн харилцагчдыг тус компанид бүрэн шилжүүлээд байна.

2010 оны эхний хагас жилийн байдлаар тус Хороонд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдаас 213 орчим өргөдөл гомдол ирсэн байх ба Хороо хуульд заасан чиг үүргийн хүрээнд шийдвэрлэж хохирлыг барагдуулах, өмчлөх эрхийг сэргээх, буруутай этгээдэд хариуцлага ногдуулах зэрэг арга хэмжээ авч шийдвэрлсэн болно.

Монголын ихэнх бүртгэлтэй хувьцаат компаниудын хувьцааны хяналтын багцаас дээш хувийг цөөхөн тооны томоохон хувьцаа эзэмшигч нар эзэмшдэг бөгөөд тэдгээр нь компанийн үйл ажиллагааг удирдаж, нийтийн /public/ компанийг хувийн ганц нэг хүний хөрөнгө мэтээр ашиглах, үнэгүйдүүлэх, ашиггүй мэт харагдуулах, ашиг орлогоос зөвхөн өөрсдөө хүртэх зэргээр дураар авирлах үйлдэл ихээр гардаг бөгөөд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, ХНХ-ыг хуралдуулаагүй, санхүүгийн тайланг Хороонд ирүүлээгүй, ТУЗ болон, гүйцэтгэх удирдлагын эрх хүчингүй болсон, компанийн өмч хөрөнгийг үрэгдүүлсэн компаниудын тухайн үед удирдаж байсан удирдлага болон томоохон хувьцаа эзэмшигч нарыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлээд байна.

Хороо иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулагчдын боловсролыг дээшлүүлэх замаар тэдний эрх ашгийг хамгаалах хамгийн зөв гарц гэж Хороо үзэж энэхүү чигэлээр нийтийг хамарсан “Иргэдийн санхүүгийн боловсролд” гэсэн бүсчилсэн өдөрлөгийг УБ хотын Баянгол, Сүхбаатар дүүргүүд, Орхон, Хөвсгөл, Өвөрхангай, Дундговь, Дорнод аймгийн төвүүдэд амжилттай зохион байгуулж, иргэдэд сургалт хийгээс гадна, зохих гарын авлага, хууль тогтоомжийн эмхтгэлийг хүргэж, радио, телевиз, сонин хэвлэл, товхимол зэрэг хэлбэрээр иргэдэд зориулсан мэдээлэл, сурталчилгааг хүргэж ажиллаа.

Хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад болон сонирхсон бусад талуудад Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээллийг хүргэх үүднээс компанийн гаргасан шийдвэр, санхүүгийн тайлангийн хураангуй, хувь нийлүүлэгчдийн хурлын материал болон бусад мэдээллийг Хороо өөрийн цахим хуудсанд мэдээллийн бааз үүсгэн байршуулж хувьцаа эзэмшигчдэд хүргэн ажиллаж байна.